

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 91.040.30

Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал	MNS 6058 : 2009
Methodology of housing unit area calculation in residential buildings	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 52 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2010 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ ба хэрэглэх хүрээ

1.1 Орон сууцны барилгын доторх сууцны талбайн хэмжээг тооцох арга зүйг тодорхойлоход хамаарна.

1.2 Орон сууцны барилгын дундын өмчлөлийн талбайн хэмжээг тооцоход энэхүү стандартыг хэрэглэнэ.

2 Норматив ишлэл

- БНБД 31-01-01, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм.
- БНБД 31-09-07, Нэг айлын орон сууцны барилгын төлөвлөлт, угсралт.
- MNS 5611 : 2006, Орон сууцны барилгад тавих үндсэн шаардлага.
- MNS 3-055 : 2000, 90 градусын шалгалтын өнцөг хэмжигч. Шалгах арга, хэрэгсэл.
- MNS 3-094 : 1982, Хуваарьт уртын хэмжүүр. Шалгах арга хэрэгсэл.
- MNS 3-103 : 1985, Хуваарьт уртын хэмжүүр. Үлгэр жишээ 2-р зэргийн хуваарьт уртын хэмжүүр ба хуваарьт уртын нарийвчлалын 1-р ангийн 1м хүртэл урттай хэмжүүр.
- MNS 3-113 : 1986, Хуваарьт уртын хэмжүүр. Үлгэр жишээ туузан метр, хэмжлийн металл рулетка. Шалгах арга, хэрэгсэл.
- MNS 4951 : 2000, Сүмбэн метр. Техникийн ерөнхий шаардлага.
- MNS 5405 : 2004, Хуваарьт уртын хэмжүүр, Төмөр шугам. Шалгах арга хэрэгсэл

3 Нэр томъёо ба тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэх нэр томъёо, тодорхойлолтыг дараах утгаар ойлгоно.

3.1

Сууцны зориулалттай талбай - дангаар өмчлөх сууцны зориулалттай хэсэг (зочны, унтлагын, хүүхдийн, ажлын г.м.)-ийн талбай хамаарна /1а - зураг/.

3.2

Сууцны бус зориулалттай талбай - дангаар өмчлөх сууцны бус зориулалттай хэсэг (гал тогооны, хооллох өрөө, ариун цэврийн болон угаалгын өрөө, өрөө

MNS 6058 : 2009

хоорондын хонгил, агуулах, ханын (хувцасны) шүүгээ,) -ийн талбайг тооцно /1а- зураг/;

3.3

Сууцны бус зориулалттай туслах талбай- лоож, тагт, террас, веранд гэх мэт бие даан орших чадваргүй сууцны барилгын туслах бүтээцийн талбай хамаарна.

3.4

Сууцны нийт талбай - сууцны зориулалттай талбай, сууцны бус зориулалттай талбай болон туслах талбайн нийлбэр байна. Гэхдээ лоожийн талбайг 0,5; тагт, террасын талбайг 0,3 гэсэн илтгэлцүүрээр бууруулан тооцно. /1а, 1б -зураг/

3.5

Лоож - барилгын гадна ханаас илүү гараагүй гурван талдаа ханатай, хучилттай ил тасалгааг; /4-р зураг/

3.6

Тагт - барилгын гадна ханаас илүү гарсан, консоль буюу баганан тулаастай, хоёр гурван талаараа хайс, хашлагатай тавцанг; /4-р зураг/

3.7

Террас - барилгад залгаж барьсан, эргэн тойрондоо хайс, хашлагатай, (дээвэртэй байж болно), доод давхрын дээвэр дээр буюу газраас дээш нэг буюу хэдэн гишгүүрийн дээр байрласан том хэмжээний задгай талбайг; /3-р зураг/

3.8

Веранд - барилгын үндсэн дээвэрт багтсан буюу барилгад залган барьсан дээвэртэй, хоёр болон гурван талыг нь шиллэсэн халаалтгүй тасалгааг; /2-р зураг/

3.9

Агуулах - эд зүйлс хадгалахад зориулагдсан тасалгааг;

4 Хэмжих хэрэгсэлд тавих шаардлага

4.1 Хэмжих хэрэгсэлд нь MNS 3-055 : 2000, MNS 3-094 : 1982, MNS 3-103 : 1985 MNS 3-113 : 1986, MNS 4951 : 2000, MNS 5405 : 2004 стандартын шаардлага хангасан байна.

5 Хэмжилт хийх бэлтгэл ажил

5.1 Сууцны талбайг хэмжихээс өмнө тухайн сууцны өрөө тасалгааны байгуулалт зураг 2 %, стандартын шаардлага хангасан хэмжих хэрэгсэл, В. хавсралтад заасан маягтыг бэлтгэсэн байна.

6 Орон сууцны барилгын доторх сууцны талбайн хэмжилтийн хүлцэх алдаа

6.1 Орон сууцны барилгын доторх сууцны талбайн хэмжилтийг дараалан 2 удаа хэмжиж дундажаар авна. Хэмжилтүүдийн зөрүү нь 1-р хүснэгтэд заасан хүлцэх алдаанаас хэтрэхгүй байна. Хэтэрсэн тохиолдолд дахин хэмжилтийг гүйцэтгэнэ.

1-р хүснэгт – Хэмжилтийн зөрүү

№	Хэмжих хэрэгслийн төрөл	Хэмжилтийн хүлцэх алдаа
1	Төмөр метр	$\Delta L = \pm 0,0005L (L > 10)$ $\Delta L = \pm 0,0001L (L \leq 10)$
2	Бусад төрлийн хэмжих хэрэгсэл	$\Delta L = \pm 0,001$

1-Р ТАЙЛБАР: ΔL - Хоёр удаагийн хэмжилтийн зөрүү
 L - хэмжилт хийсэн уртын хэмжээ

7 Орон сууцны барилгын доторх сууцны нийт талбайг хэмжих

7.1 Орон сууцны барилгын доторх сууцны нийт талбай нь 2-р хүснэгтэд заасны дагуу тухайн сууцны ашиглаж болох бүхий л өрөө, тасалгаа, талбайн нийлбэр байна.

2-р хүснэгт - Орон сууцны барилгын доторх сууцны нийт талбай

№	Өрөө, тасалгааны нэр	Талбайн хэмжээ, м ²	Тайлбар
<u>Сууцны зориулалттай талбай</u>			
1	Зочны	S_1	
2	Унтлагын	S_2	
3	Хүүхдийн	S_3	
4	Ажлын	S_4	
<u>Сууцны бус зориулалттай талбай</u>			
5	Гал тогооны	S_5	
6	Хооллох	S_6	
8	Ариун цэврийн	S_7	
9	Агуулах	S_8	
10	Хонгил	S_9	
11	Угаалгын	S_{10}	
<u>Сууцны бус зориулалттай туслах талбай</u>			
12	Лоож	S_L	0,5 гэсэн илтгэлцүүр хэрэглэнэ
13	Тагт	S_T	0,3 гэсэн илтгэлцүүр хэрэглэнэ
14	Террас	S_{Te}	0,3 гэсэн илтгэлцүүр хэрэглэнэ
15	Веранд	S_B	
$S_{C \text{ нийт}} = S_1 + S_2 + S_3 + \dots + S_{10} + 0,5S_L + 0,3S_T + 0,3S_{Te} + S_B$		$S_{C \text{ нийт}}$	Тухайн сууцны нийт талбай

2-Р ТАЙЛБАР: -Зөвхөн тухайн сууцны өрөө, тасалгааны талбайг тооцно.

7.2 Орон сууцны барилгын доторх сууцны өрөө тасалгааны хэмжилтийн цэгийг хашлага хана, хамар ханын өнгөлгөө засал хийгдсэний дараа дотор гадаргуугаас авна.

7.3 Хэмжилт хийх цэгийг шалны түвшнээс дээш $(1,2 \pm 0,2)$ метрт, өрөөний 2 урт талын болон 2 богино талын $1/6$ болон $5/6$ -д тэгш хэмд 2 цэгийг сонгоно.

7.4 Тэгш өнцөгт бус хэлбэртэй өрөө, тасалгааг геометрийн хэсгүүдэд /дөрвөлжин гурвалжин, дугуй, зуйван гэх мэт/ хуваан хэмжиж, хэсэг тус бүрийн талбайн нийлбэрээр тухайн өрөө, тасалгааны талбайг тодорхойлно. /5-р зураг/

7.5 Адар (мансард)-ын давхарын өрөөний талбайн хэмжээг тогтоохдоо хэмжилт хийх цэгийн өндрийг таазны налуугаас нь хамааралтайгаар: налуу нь 30° хүртэл бол өндөр нь 1,2 м; 30° -аас 45° бол өндөр нь 1,1 м; 45° -аас 60° , болон түүнээс дээш тохиолдолд өндрийг нь 0,5 метрт байхаар тооцно. /6-р зураг/

7.6 Талбайн хэмжээг тооцсон тооны бутархайн орон нь 2 байх ба хэмжих нэгж нь ам дөрвөлжин метрээр илэрхийлэгдэнэ.


8 Орон сууцны барилгын доторх сууцны талбайг шалгах, баталгаажуулах

8.1 Орон сууцны барилгын доторх сууцны талбайн хэмжилтийг барилгын зураг төсөл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж үйлдвэл зохино.


8.2 Хэмжилт хийж баталгаажуулах хэсгийн хэмжилтийн зураг, талбайн хэмжээг А.хавсралтын дагуу гаргаж хуудас болгоныг баталгаажуулна.

ТӨГСӨВ.


А.хавсралт (норматив)



Огтлол 1-1




Огтлол 2-2



16 зураг - Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал


Веранд

Огтлол




Веранд

Байгуулалт




2-р зураг - Орон сууцны барилгын доторх сууцны талбай
тооцох аргачлал

Террас
Огтлол




Террас
Байгуулалт




3-р зураг - Орон сууцны барилгын доторх сууцны талбай
тооцох аргачлал


Лоож
Огтлол




Тагт
Огтлол




Лоож
Байгуулалт



Тагт
Байгуулалт




4-р зураг - Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал




Адрын давхар


45°-60°-ийн налуутай үед



30°-45°-ийн налуутай үед



30° хүртэл налуутай үед



6-р зураг - Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал

**В.хавсралт
(норматив)**

**СУУЦНЫ ӨРӨӨ, ТАСАЛГААНЫ ХЭМЖИЛТ ХИЙЖ,
ТҮҮНИЙ ТАЛБАЙГ ТООЦСОН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо.

Дугаар

Хэмжилт хийсэн байгууллага:.....

Гүйцэтгэгч байгууллага:.....

Хөрөнгө оруулагч (захиалагч):.....

Барилгын нэр:

Сууцны төрөл:.....

Байршил:(аймаг, хот).....(дүүрэг, сум).....(хороо,
баг).....-р байрны -р орцнытоот

СУУЦНЫ ТАЛБАЙ ТООЦСОН ТЭМДЭГЛЭЛ

	Өрөө, тасалгааны нэр	Урт /м/			Өргөн /м/			Талбайн хэмжээ /м ² /
		1 дүгээр хэмжилт	2 дугаар хэмжилт	Дундаж	1 дүгээр хэмжилт	2 дугаар хэмжилт	Дундаж	
Сууцны зориулалттай талбай								
1	Амралтын							S₁
2	Унтлагын							S₂
3	Хүүхдийн							S₃
4	Ажлын							S₄
Сууцны бус зориулалттай талбай								
5	Гал тогооны							S₅
6	Хооллох							S₆
7	Ариун цэврийн							S₇
8	Агуулах							S₈
9	Хонгил							S₉
10	Угаалгын							S₁₀
Сууцны бус зориулалттай туслах талбай								
11	Лоож							S_л
12	Тагт							S_т
13	Террас							S_{те}
14	Веранд							S_в

ТАЙЛБАР: Шаардлагатай тохиолдолд хүснэгтийн хэмжээг томсгохыг зөвшөөрнө.

В. хавсралтын үргэлжлэл

СУУЦНЫ НИЙТ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

$$S_{\text{С НИЙТ}} = S_1 + S_2 + S_3 + \dots + S_{10} + 0,5S_{\text{Л}} + 0,3S_{\text{T}} + 0,3S_{\text{Tе}} + S_{\text{В}}$$

ДҮГНЭЛТ

<p>Дүгнэлт гаргасан:(гарын үсэг)..... /овгийн эхний үсэг, нэр/</p>
--

ТАЙЛБАР: Шаардлагатай тохиолдолд хүснэгтийн хэмжээг томсгохыг зөвшөөрнө.

БАТЛАВ:

ХЭМЖИЛТ ХИЙСЭН:

Байгууллагын Захирал (тамга)	(гарын үсэг)	/овгийн эхний үсэг, нэр/
Шалгасан:	(гарын үсэг)	/овгийн эхний үсэг, нэр/
Хэмжилт хийсэн:	(гарын үсэг)	/овгийн эхний үсэг, нэр/
Хэмжилт хийсэн:	(гарын үсэг)	/овгийн эхний үсэг, нэр/